



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 20 өдөр

Дугаар N584

Номгон

Томуу, томуу төст өвчлөлөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад сургууль, цэцэрлэгийн насны хүүхдүүд, жирэмсэн эхчүүдийг хамруулах ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "в", 29.2, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/565 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын 2021 оны 63 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Томуугийн улирал ирж байгаатай холбогдуулан томуу, томуу төст өвчлөлд өртөх эрсдэлтэй сургууль, цэцэрлэгийн насны хүүхдүүд болон жирэмсэн эхчүүдийг дархлаажуулалтын вакцинд хамруулах ажлыг 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 2021 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийг хүртэл хугацаанд өдөр бүрийн 10:00-18:00 цагуудад зохион байгуулсугай.

2.Томуу, томуу төст өвчлөлөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, дархлаажуулалтын ажлын удирдамжийг 2 дугаар, шаардагдах зардлыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 2,100,000 (Хоёр сая нэг зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч дарга, хурандаа (Ж.Алтангэрэл)-д үүрэг болгосугай.


ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601210369

Аймгийн Засаг даргын \_\_\_\_\_ оны 09...  
дугаар сарын 20 өдрийн 1534 дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт



**ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧЛӨЛӨӨС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЖЛЫГ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

Онцгой байдлын газрын орлогч,  
дэд хурандаа Э.Батбаяр

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга  
Б.Наранбаяр

Баянхонгор сумын Засаг дарга Ж.Мөнхсоёл

Боловсрол, соёл урлагийн газрын  
дарга Ц.Энхтөр

Эрүүл мэндийн газрын Нийгмийн Эрүүл  
мэндийн төвийн дарга Д.Балжмаа

Мэргэжлийн хяналтын газрын  
Эм биобэлдмэлийн хяналтын улсын  
байцаагч А.Энхзаяа


Цагдаагийн газрын Нийтийн хэв журам  
хамгаалах тасгийн дарга,  
дэд хурандаа Б.Мөнгөнтулга

Нарийн бичиг:

Онцгой байдлын газрын Гамшгийн  
эрсдэлийн удирдлага, үнэлгээ дотоод ажил  
хариуцсан мэргэжилтэн, дэслэгч  
Д.Энхсайхан

Онцгой байдлын газрын эмч, сэтгэл  
зүйч М.Бат-Эрдэнэ

Аймгийн Засаг даргын ... оны ... дугаар сарын ... өдрийн ... дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



**ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧЛӨЛӨӨС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЖЛЫН  
УДИРДАМЖ**

**Нэг. Зорилго:**

Томуугийн халдвараас сургууль, цэцэрлэгийн насны хүүхдүүд болон жирэмсэн эхчүүдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх тарилгад шуурхай хамруулахад энэхүү удирдамжийн зорилго оршино.

**Хоёр. Авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

Д/д	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн
1	Томуугийн дархлаажуулалтад хамруулах сургууль, цэцэрлэгийн насны хүүхдүүдийн судалгаа гаргах,	2021.09.20	Боловсрол, соёл урлагийн газрын дарга Ц.Энхтөр
2	Томуугийн дархлаажуулалтад хамруулах жирэмсэн эхчүүдийн нэгдсэн судалгаа гаргах, судалгааг нэгтгэх	2021.09.20	Эрүүл мэндийн газрын Нийгмийн Эрүүл мэндийн төвийн дарга Д.Балжмаа
3	Томуугийн дархлаажуулалтын нэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөө гаргах	2021.09.20	Ажлын хэсэг
4	Томуугийн дархлаажуулалтын арга хэмжээний талаар орон нутгийн телевиз, мэргэжлийн байгууллагын албан ёсны цахим хуудсаар сурталчилгаа, мэдээллийг дээрх хугацаанд тогтмол мэдээлэх	2021.09.20-26	Эрүүл мэндийн газрын Нийгмийн Эрүүл мэндийн төвийн дарга Д.Балжмаа
5	Сумдын Эрүүл мэндийн төвүүдийг томуугийн дархлаажуулалтын нэгдсэн мэдээллээр хангах	Тухай бүр	Ажлын хэсэг
6	Томуугийн дархлаажуулалтын ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах	Тухай бүр	Ажлын хэсэг
7	Томуугийн дархлаажуулалтын тайлан нэгтгэх	2021.09.26	Онцгой байдлын газрын Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, дэслэгч Д.Энхсайхан

**Гурав. Хамрах хүрээ**


Тус аймгийн сургууль, цэцэрлэгийн насны 19838 хүүхэд болон жирэмсэн 935 эхчүүдийг хамруулна.

**Дөрөв. Хугацаа**

2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 2021 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулагдана.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

Аймгийн Засаг даргын \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_ өдрийн \_\_\_\_\_ дугаар захирамжийн 3 дугаар кавсралт



ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧЛӨЛӨӨС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЖИЛД  
ШААРДАГДАХ ЗАРДАЛ

Д/д	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	Автобусны жолоочийн томилолт	Өдөр	6	20,000*7 өдөр	840,000
2	Өдрийн хоол	ширхэг	3	10,000*7 өдөр	1,260,000
3	Нийт	-	7	-	2,100,000

-----oOo-----